



**“ТАВАНТОЛГОЙ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН
ТОГТООЛ**

2023 оны 04 сарын 21 өдөр

Дугаар 01

Тавантолгой

**“Тавантолгой” ХК-ийн 2022 оны үйл ажиллагааны
болон санхүүгийн тайланг батлах тухай**

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.15 дахь заалт, “Тавантолгой” ХК-ийн дүрмийн 6 дугаар зүйлийн 6.14.13 дахь заалт, Тооллогын комиссын 2023 оны 04 дүгээр сарын 21-ний өдрийн 02 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Тавантолгой” ХК-ийн 2022 оны үйл ажиллагааны тайланг хангалттай гэж дүгнэсүгэй.
2. Хөндлөнгийн аудитын байгууллагаар оруулж баталгаажуулсан санхүүгийн тайланд дүгнэлт өгөхийг Төлөөлөн удирдах зөвлөлд зөвшөөрсүгэй.
3. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал дээр гарсан санал дүгнэлтийг 2023 оны үйл ажиллагааны бодлого шийдвэртээ тусгаж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөл, Гүйцэтгэх удирдлага нарт даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА



Г.ЦОГ-ӨРНӨХ



**“ТАВАНТОЛГОЙ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН
ТОГТООЛ**

2023 оны 04 сарын 21 өдөр

Дугаар 02

Тавантолгой

“Тавантолгой” ХК-ийн 2022 оны үйл
ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх
Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг батлах тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9 дэх заалт, “Тавантолгой” ХК-ийн дүрмийн 6 дугаар зүйлийн 6.14.9 дэх заалт, Тооллогын комиссын 2023 оны 04 дүгээр сарын 21-ний өдрийн 02 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Тавантолгой” ХК-ийн 2022 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн “Хангалттай” гэж дүгнэсэн дүгнэлтийг хүлээн зөвшөөрч баталсугай.
2. Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг цаашид бодлого шийдвэртээ тусгаж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөл, Гүйцэтгэх удирлагад даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА



Г.ЦОГ-ӨРНӨХ



**“ТАВАНТОЛГОЙ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН
ТОГТООЛ**

2023 оны 04 сарын 21 өдөр

Дугаар 03

Тавантолгой

Ногдол ашгийн талаар мэдээлэх тухай

Компанийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.2, 46.15 дахь хэсэг, “Тавантолгой” ХК-ийн дүрмийн 6 дугаар зүйлийн 6.14.13 дахь заалт, Тооллогын комиссын 2023 оны 04 дүгээр сарын 21-ний өдрийн 02 тоот тогтоолыг тус тус үндэслэн **ТОГТООХ** нь:

1. “Тавантолгой” ХК-ийн 2021 оны ногдол ашиг тараалтын тайлан, 2022 оны жилийн эцсийн урьдчилсан санхүүгийн тайланд тусгагдсан цэвэр ашгаас ногдол ашиг болгон хуваарилах талаар Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 02 дугаар сарын 25-ны өдрийн 34 дугаар тогтоолтой танилцуулсаныг тэмдэглэсүгэй.
2. Санхүүгийн тайланг хөндлөнгийн аудитаар баталгаажуулсаны дараа нэмэлт байдлаар ногдол ашиг хуваарилахыг Төлөөлөн удирдах зөвлөлд үүрэг болгосугай.
3. 2022 оны ногдол ашгийг хувьцаа эзэмшигчдэд бүрэн олгох ажлыг зохион байгуулахыг Гүйцэтгэх удирдлагад үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА



Г.ЦОГ-ӨРНӨХ



**“ТАВАНТОЛГОЙ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН
ТОГТООЛ**

2023 оны 04 сарын 21 өдөр

Дугаар 04

Тавантолгой

**Төлөөлөн удирдах зөвлөлийн
гишүүдийг сонгох тухай**

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.7 дахь заалт, “Тавантолгой” ХК-ийн дүрмийн 6 дугаар зүйл 6.14.7 дахь заалт, 77 дугаар зүйлийн 77.4 дэх хэсэг, Тооллогын комиссын 2023 оны 04 дүгээр сарын 21-ний өдрийн 03 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Тавантолгой” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн, хараат бус гишүүдийг санал хураах кумулятив аргаар дараах бүрэлдэхүүнтэй сонгосугай. Үүнд:

- 1.1. Лхачингийн Батчулуун /ердийн гишүүн/
- 1.2. Буриадын Батдорж /ердийн гишүүн/
- 1.3. Шоовдорын Баянбат /ердийн гишүүн/
- 1.4. Ганбаатарын Ганчимэг /ердийн гишүүн/
- 1.5. Дашзэгвийн Дагвадорж /ердийн гишүүн/
- 1.6. Цэнд-Аюушийн Цэнгэлбаяр /ердийн гишүүн /
- 1.7. Галсандоржийн Цог-Өрнөх /хараат бус гишүүн /
- 1.8. Доржпаламын Нацагдорж /хараат бус гишүүн
- 1.9. Эрдэнийн Бямбажав /хараат бус гишүүн /

2. Шинээр сонгогдсон Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг хууль тогтоомжийн дагуу идэвхи санаачлагатай ажиллахыг үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА



Г.ЦОГ-ӨРНӨХ



**“ТАВАНТОЛГОЙ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН
ТОГТООЛ**

2023 оны 04 сарын 21 өдөр

Дугаар 05

Тавантолгой

Төлөөлөн удирдах зөвлөлийн
2023 оны төсөв батлах тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.13, 62.1.15 дах заалт, “Тавантолгой” ХК-ийн дүрмийн 6 дугаар зүйлийн 6.14.12, 6.14.13 дахь заалт, Тооллогын комиссын 2023 оны 04 дүгээр сарын 21-ний өдрийн 02 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Тавантолгой” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны үйл ажиллагааны төсвийг хавсралтаар баталсугай.
2. Төлөөлөн удирдах зөвлөлийн зардлын төсөвт хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн Цалин урамшууллын хороонд даалгасугай.
3. Төлөөлөн удирдах зөвлөлийн төсвийг санхүүжүүлэхийг Гүйцэтгэх удирдлагад зөвшөөрсүгэй.

ХУРЛЫН ДАРГА



Г.ЦОГ-ӨРНӨХ